

## Ард Санхүүгийн Нэгдлийн 2018 оны II улирлын тайлан

### Үндсэн үзүүлэлт

Тэрбум төгрөг (өөрөөр заагаагүй бол)	Q2 2018	Q1 2018
Нийт хөрөнгө	51.88	50.78
Урт хугацаат хөрөнгө оруулалт	40.93	41.09
Зээлийн багц	7.22	2.43
Крипто хөрөнгө оруулалт	9.84 Биткойн	9.84 Биткойн
Өр төлбөр	5.90	6.15
Хойшлогдсон татвар	1.49	1.51
Урт хугацаат	2.78	2.77
Богино хугацаат	1.60	1.60
Өөрийн хөрөнгө	46.00	44.80
Ногдол ашгийн орлого (2017 онд 0.35 тэрбум төгрөг)	0.90	
Ашиг	0.95	-0.34
Нийт компанийн үнэлгээ	47.50	46.30
Нэгж хувьцааны үнэлгээ	2,763 төгрөг	3,065 төгрөг
JIV үнэ	1,490 төгрөг	1,709 төгрөг
MNP үнэ	578 төгрөг	581 төгрөг
Биткойны үнэ	15.9 сая төгрөг	

### Харьцаа үзүүлэлтүүд

	2017Q2	2017Q4	2018Q2	YoY %
Зээл/хөрөнгийн харьцаа	12.0%	5.1%	13.9%	15.8%
Өр төлбөр (хүүтэй)/хөрөнгийн харьцаа	7.70%	7.60%	7.80%	1%
Хөрөнгө оруулалт/хөрөнгийн харьцаа	69.10%	78.60%	78.90%	14.0%
Хөрөнгө оруулалт/өөрийн хөрөнгийн харьцаа	74.30%	90.50%	89.00%	20%
Зардал/хөрөнгийн харьцаа	3.10%	5.50%	3.20%	4%
Цалин/хөрөнгийн харьцаа	1.40%	0.80%	0.60%	-58%
ҮАЗардал/хөрөнгийн харьцаа	1.30%	3.90%	2.00%	52.0%
Санхүүгийн зардал/хөрөнгийн харьцаа	0.40%	0.80%	0.60%	66%
ROE	-1.30%	0.20%	2.10%	-265%
ROA	-1.20%	2.10%	1.90%	-257%

## Эдийн засаг, зах зээл

Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөлийн 2018 оны 3 сарын ээлжит хуралдаанаар бодлогын хүүг 1.0 нэгж хувиар бууруулж, 10.0 хувь болгох шийдвэр гаргасан бол 6 дугаар сард хүүний түвшинг хадгалахаар шийдсэн байна. Гадаад эрэлт хүлээлтээс илүү байж, экспортын бүтээгдэхүүний үнэ өндөр түвшинд хадгалагдан төлбөрийн тэнцэл болон эдийн засгийн төлөвт эерэг нөлөө үзүүлсэн төдийгүй эдийн засгийн идэвхжлийг даган эрэлтийн шалтгаантай инфляци алгуур нэмэгдсэн ч жилийн инфляци цаашид зорилтот түвшний (8 хувь) орчим тогтворжихоор байгаа болно. Иймд банкны салбарын богино хугацаатай эх үүсвэрийн хүүг бууруулж, улмаар зээлийн хүүгээр дамжин бизнесийн идэвхжлийг дэмжих зорилгоор мөнгөний бодлогын хүүг тогтвортой барих энэхүү шийдвэрийг гаргасан байна.

Ард Кредит болон Ард Актив өөрийн олгож байгаа зээлийн хүүгээ зах зээлийг даган буулгах шийдвэрийг гарган ажиллаж байгаа бөгөөд бидний бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгөд төлдөг бондын купон, итгэлцэл, хадгаламжийн хүүний түвшин мөн буурах хандлагатай байна.

2018 оны II улиралд инфляци хүлээгдэж байснаас бага зэрэг өндөр буюу 7.2 хувь гарсан нь тухайлсан нэг бүтээгдэхүүний үнэ буюу хатуу түлшний үнийн өсөлттэй холбоотой. Цаашид эдийн засгийн сэргэлттэй холбоотой эрэлтийн шалтгаантай инфляци нэмэгдэх хүлээлттэй байгаа ч ирэх онуудад харьцангуй тогтвортой байж, зорилтот түвшний орчимд тогтворжих төлөвтэй байна.

Дотоодын нийт бүтээгдэхүүн 2018 оны эхний улиралд 6.626 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Нийт мөнгөний нийлүүлэлт 2018 оны 6 сард 17.3 их наяд төгрөг хүрч өмнөх оны мөн үеэс 3.9 их наяд төгрөг буюу 28.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Мөнгөний нийлүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдээс валютын хадгаламж 4.4 хувь, төгрөгийн хадгаламж 1.2 хувь, төгрөгийн харилцах 4.4 хувиар өсчээ.

Банкиудын нийт зээлийн үлдэгдэл 2018 оны 6 дугаар сарын байдлаар 15.4 их наяд төгрөгт хүрч жилийн 19.4 хувиар өсжээ. Үүнээс иргэдэд олгосон зээл 7.3 их наяд буюу жилийн 25.1 хувийн өсөлт, хувийн байгууллагад олгосон зээл 7.4 их наяд буюу 11.8 хувийн өсөлтийг тус тус үзүүлэв (5 сарын байдлаар).

Төгрөгийн доллартай харьцах Монголбанкны нэрлэсэн дундаж ханш 2018 оны 5 сард 2,405.19 төгрөг байсан бол 6 сард 2,462.82 болж сулрав.

## Хөрөнгийн зах зээл

Нийт зах зээлийн үнэлгээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 984.2 тэрбум төгрөгөөр буюу 65.7 хувиар өсч, 2 их наяд 481.8 тэрбум төгрөг болсон байна.

2018 оны эхний хагас жилд хувьцааны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаар нийт 384.5 сая ширхэг хувьцааг 49.5 тэрбум төгрөгөөр, ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаагаар 276.0 мянган ширхэг үнэт цаасыг 27.5 тэрбум төгрөгөөр, компанийн бондын хоёрдогч зах зээлийн арилжаагаар 6.3 мянган ширхэг “Сүү бонд”-ыг 631.6 сая төгрөгөөр тус тус арилжиж, нийт 77.6 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий арилжаа хийсэн байна.

Тайлант хугацаанд өдөрт дунджаар 616.6 сая төгрөгийн гүйлгээ хийж, 3.0 сая ширхэг үнэт цаас арилжсан байна. Идэвхитэй арилжигдсан 20 хувьцаат компаниас үнийн дүнгээр Жинст Увс 10-т, Монгол Шуудан 16-т жагсаж байна.

## Гүйцэтгэлийн тойм

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа бид 4 дүгээр сарын 28-нд амжилттай зохион байгуулж, Жинст Увс/Хөрөнгө Оруулагч Үндэстэн ХК-тай нэгдэх байдлаар *нээлттэй хувьцаат компани* болох түүхэн шийдвэр гаргав. Ард Даатгал дүрмийн сангаа нэмэгдүүлэх зорилгоор *IPO хийхээр* болж, СЗХ болон МХБ-д холбогдох материалыг хүргүүлэн ажиллаж байгаа бол Ард Кредит компанийн хувьд үнэлгээ, хуулийн дүгнэлт болон проспектусаа эцэслэх шатандаа орон ажиллаж байна. Ард Даатгалын өргөдлийн хариуд Монголын Хөрөнгийн Биржийн захирлын тушаал гарч нэгдүгээр самбарт бүртгэн AIC гэх тикер оногдуулах шийдвэрийг гаргасан байна.

Бидэнтэй олон жил хамтран ажилласан ВенчюрсУан компани өөрийн өмчийн 1,316,103 ширхэг хувьцаагаа манай *ажиллагсдын хувь нийлүүлсэн EIT компанид* худалдсанаар Энтони Хоброу ТУЗ-ийн гишүүнээс гарсан болно. Мөн Луна Энд Луна компани өөрийн 1,233,154 ширхэг хувьцаагаа Монгол Шуудангийн 3.6 хувиар *солилцох гэрээг* үзэглэснээр манай ТУЗ-ийн дарга, гишүүнээр 2013 оноос хойш ажиллаж ирсэн Оюунгэрэл мөн ТУЗ-ийн бүрэлдэхүүнээс чөлөөлөгдөв. Бид эдгээр орон тоонд хоёр хараат бус ТУЗ-ийн шинэ гишүүнийг томилохоор шийдэж SGS компанийн захирал *Мөнхбат*, ТТДС-ийн захирал *Сэргэлэн* нарыг бүрэлдэхүүндээ урьж ажиллуулж эхлээд байна.

Хөрөнгө Оруулагч Үндэстэн компани Жинст Увстай нэгдсэнтэй холбогдуулан татан буулгах ажлыг 5 дугаар сард эцэслэсэн болно. Ингэснээр Монголын анхны урвуу нэгдлийн үйл ажиллагааг бид 2 жилийн хугацаанд тасралтгүй ажилласны үр дүнд амжилттай хаалаа. Цаашид Ард Санхүүгийн Нэгдэл *Жинст Увстай нэгдэх замаар* нээлттэй компани болох тул МХБ-ийн хувьцааны тикер JIV байгааг *ARD* болгох тухай хүсэлтийг гарган МХБ, СЗХ болон ҮЦТХТ-тэй харилцан ажиллаж байна.

Бид *Блокчэйн Академийн* үйл ажиллагааг амжилттай эхлүүлж, 20 гаруй оюутныг бэлтгэн 5 шинэ төсөл эхлүүлсэн бөгөөд Монголын анхны Биткойн хэтэвч болох *ГоүПэй ХХК*-ийн 60 хувьд хөрөнгө оруулж, *Биткойн барьцаалсан зээлийг* амжилттай боловсруулж дууслаа. Туршилтыг бид 3 дугаар улирлын туршид явуулахаар төлөвлөж байна. Үүний хажуугаар Грэйп Сититэй байгуулсан стратегийн түншлэлийн гэрээний дагуу Ард Кредит, Ард Актив болон Ард Лайфд үндсэн банкны системийг нэвтрүүлэн группын хэмжээнд *нэгдсэн датабаазын* сууриа амжилттай тавьснаар бидний зорилгоо болгосон дижитал шилжилтийн нэгэн хуудас эргэлээ. Ард Кредит *АрдПэй* мобайл хэтэвчийг зах зээлд анхлан нэвтрүүлж цаашид нэгдлийн бүх компаниуд ажил гүйлгээгээ үүгээр дамжуулдаг болохоор ажиллаж байна. Ард Кредит *хувьцаа барьцаалсан зээлийг* зах зээлд нэвтрүүлсэн бол бид хувь нийлүүлэгчдийн хурлаараа *Ард Базаарын* нээлтийг хийлээ.

Ард Лайфын харилцагчдын тоо 1,000-д хүрлээ. Монгол Шуудан ХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж удирдах түвшний ажилчид нь эхнээсээ хамрагдаж эхэллээ. Ард Лайф *Поларис банкны системд* нэгдсэнээр тэтгэврийн хуримтлалын үлдэгдлээ АрдПэй мобайл хэтэвчээр шалгах боломжтой болж байна.

Ард Менежментийн хувьд *Хувьчлалын Сан* нэртэй хамтын нээлттэй сан байгуулах бичиг баримтаа СЗХ-нд хүргүүлэв. Манай голлох компаниудад СЗХ-ны ээлжит шалгалтууд хийгдэж, дүнгээ нэгтгэж байна. Ард Кредит дээр татвар болон нийгмийн даатгалын шалгалт орж дууссан бол Ард Даатгал дээр татварын шалгалт орсон байгаа болно.

Бид 2 дугаар сард Сэнтрал Тауэрт Монгол Шуудантай *хамтарсан салбар* нээх шийдвэрийг гарган ажилласны үр дүнд тус салбар 6 дугаар сарын 29-нд албан ёсны нээлтээ хийгээд байна. Энэ байршилд бид шуудангийн дэд бүтцийг ашиглан санхүүгийн үйлчилгээг хүргэж эхлэх, гадаад дотоодын гуйвуулгын бүтээгдэхүүн нэвтрүүлэх, интернет дээр суурилсан худалдааны үйлчилгээ рүү орох төлөвлөгөөтэй ажиллаж байна. Мөн оны эхнээс манай *Эрдэнэтийн төлөөлөгч* үйл ажиллагаагаа идэвхжүүлэн ажиллаж ирлээ.

## Санхүүгийн гүйцэтгэл

Нийт хөрөнгө 52 тэрбум төгрөг болж өнгөрсөн оны сүүлчээс 2.2 тэрбум төгрөгөөр өсөв. Энэхүү өсөлтийн 1.9 тэрбумыг урт хугацаат хөрөнгө оруулалтын үнэ цэнэд гарсан өөрчлөлт авчирсан бол бусдад олгосон зээл 2.5-аас 7.2 тэрбум хүрч өссөн нь нөлөөлжээ.

Нийт өр төлбөр 6.5-аас 5.9 тэрбум болон 0.6 тэрбум төгрөгөөр буурч харин өөрийн хөрөнгө 43.1-ээс 46 тэрбум төгрөг болж цэвэр ашиг болон хөрөнгө оруулалтын үнэлгээний ашиг 2.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн боловч бид өөрийн эзэмшилд байсан хувьцаагаа эргэлтэнд оруулснаар нэгж хувьцааны үнэ 2.763 мянган төгрөг болов.



Манай цэвэр ашиг 951 сая төгрөг гарсан бол үүнийг дангаараа шахуу биелүүлсэн зүйл бол хөрөнгө оруулалтын ашиг байлаа. Өмнө нь мэдээллэж байсны дагуу бид нийт татварын дараах 807.8 сая төгрөгийг ногдол ашгийг 3 компаниас авсан байна.

Хувьцааны хоёрдогч арилжааны идэвх сул байсантай холбогдуулан бид нийт 660 гаруй сая төгрөгний хувьцаа борлуулж, үйл ажиллагаагаа санхүүжүүлэв. Үүнээс Жинст Увс/Хөрөнгө Оруулагч Үндэстний 246.3 сая төгрөг, Монгол Шуудангийн 244.5 сая төгрөгийн хувьцааг Монголын Хөрөнгийн Биржээр арилжсан байна. Ард Санхүүгийн Нэгдлийн хувьцааг эргэлтэнд оруулах төлөвлөгөөний хүрээнд бид өөрийн эзэмшлийн нийт хувьцаагаа EIT руу зээлээр санхүүжүүлэн шилжүүлэв.

Бид ГоүПэй компанид 200 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн бол МАК-д 120 сая төгрөгний төлбөр гүйцэтгэж, Худалдаа Хөгжлийн Банкны өрөнд 100 саяыг төлсөн байна. 2017 оны Ардын Бондын купоны төлбөрт 236.6 саяыг, бусад өрөнд 333.4 саяыг төлжээ.

Ард Санхүүгийн Нэгдлийн балансан дээр 10 орчим Биткойны нөөцтэй болсон бөгөөд үүнийгээ цаашид аажмаар нэмэгдүүлэн ажиллах төлөвлөгөөтэй байна.

Далайван Аудит санхүүгийн тайлангийн аудитыг нэгдлийн хэмжээнд хийж гүйцэтгэн танилцуулав.

## **Ойрын төлөвлөгөө**

Хувьчлалын хөтөлбөрийг хэрэгжүүлэх болсонтой холбогдуулан бид Монгол Шуудан, Монголын Хөрөнгийн Бирж, Төрийн Банк болон ЭТТ-н эргэн тойронд болж байгаа үйл явдлуудыг анхааралтай ажиглаж байна. Бид Хувьчлалын Сангийн үйл ажиллагааг эхлүүлэх зорилготой ажиллаж байна.

Ард Даатгал болон Ард Кредитын IPO бидний баталсан төлөвлөгөөний дагуу 3 дугаар улиралд явагдах бөгөөд компани бүх нөөц, хүчээ энэ ажилд дайчлан ажиллах болно.

Ард Санхүүгийн Нэгдэл нэгдэх байдлаар нээлттэй хувьцаат компани болох ажлыг бид үргэлжлүүлэн энэ ондоо багтан Монголын Хөрөнгийн Биржээр хувьцаагаа арилжаалах зорилготой ажиллаж байна.

Бид олон улсын криптовалютын хоёр эксченжид хөрөнгө оруулалт хийхээр хэлэлцээр явуулж байгаа бөгөөд 3 дугаар улиралд энэ хэлцлүүдийг хаах зорилготой байна.

Төлөөлөн Удирдах зөвлөлөөс 6 сарын 28-ны өдөр гарсан шийдвэрийн дагуу компани нь нийт 4 тэрбум төгрөгийн 1 болон 2 жилийн хугацаатай хаалттай бондыг зах зээл дээр хөвөгч хүүтэй, хөрвөх нөхцөлтэйгээр гарган ажиллаж байна. Уг хаалттай бондын андеррайтераар Ард Секюритиз ҮЦК ажиллаж байгаа болно.

Монгол Шуудантай хамтран ажиллах төлөвлөгөөний дагуу ЕвроЖайро сүлжээнд нэгдэж, туршилтын горимоор ажиллаж эхлэнэ.

Бид олон улсын зах зээлээс хөрөнгө татах аргуудыг судлаж байгаа бөгөөд 9 дүгээр сард болох ТУЗ-ийн хурлаар тодорхой шийдэл танилцуулах төлөвлөгөөтэй байна.

***Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, Үнэлгээ, Санхүүгийн байдлын тайлан, Орлогын тайлан, Хувьцааны арилжааны мэдээг хавсаргав.***

## Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

#	Хувьцаа эзэмшигч	Q1 2018		Q2 2018	
1	И Ай Ти ХХК	125,277	0.83%	3,087,902	18.00%
2	Х.Батхишиг	1,689,415	11.18%	1,689,415	9.80%
3	Бруно Рашле	1,317,337	8.71%	1,317,337	7.70%
4	Луна Энд Луна ХХК	1,233,154	8.16%	1,233,154	7.20%
5	Хөрөнгө Оруулагч Үндэстэн ХК	1,020,210	6.75%	1,049,170	6.10%
6	Ч.Ганхуяг	746,389	4.94%	746,389	4.30%
7	Ард Секюритиз ҮЦК ХХК	896,532	5.93%	735,498	4.30%
8	Алтан Хоромсог ХХК	743,436	4.92%	629,035	3.70%
9	Ард Лайф ХХК	625,117	4.14%	597,047	3.50%
10	Г.Уянга	597,047	3.95%	452,000	2.60%
11	С.Гэрэлтуяа	452,000	2.99%	305,697	1.80%
12	Ронок Лимитэд	305,697	2.02%	272,656	1.60%
13	Л.Соронзонболд	272,656	1.80%	248,945	1.40%
14	М.Золжаргал	248,945	1.65%	152,830	0.90%
15	Д.Эрдэнэчимэг	152,830	1.01%	134,474	0.80%
	<b>15 хувьцаа эзэмшигч</b>	<b>10,426,042</b>	<b>68.97%</b>	<b>12,651,549</b>	<b>73.60%</b>
	2,148 хувьцаа эзэмшигч	4,691,432	31.03%	4,542,815	26.40%
	<b>Нийт хувьцаа</b>	<b>15,117,474</b>	<b>100.00%</b>	<b>17,194,364</b>	<b>100.00%</b>

## Үнэлгээ

	2017 (Audited)	Q1 2018	Q2 2018
<b>Стратегийн хөрөнгө оруулалт</b>	<b>33,711,082,500</b>	<b>35,752,986,421</b>	<b>35,587,751,318</b>
Монгол Шуудан	16,064,720,393	16,401,516,622	16,306,642,870
Хөрөнгө Оруулагч Үндэстэн	295,470,308	310,477,448	29,116,090
Ард Даатгал	9,527,681,799	9,527,681,799	9,527,681,799
Ард Кредит	4,557,999,178	4,557,999,178	4,557,999,178
Ард Секюритиз	2,126,210,823	2,126,210,823	2,126,210,829
Ард Менежмент	100,000,000	365,333,106	365,333,106
Ард Актив	29,000,000	37,726,429	47,726,429
Ард Лайф	1,010,000,000	2,426,041,017	2,426,041,017
Ард Бит			200,000,000
ГөүПэй			1,000,000
<b>Стратегийн бус хөрөнгө оруулалт</b>	<b>5,340,741,000</b>	<b>5,340,741,000</b>	<b>5,340,741,000</b>
Тэнгэр Системс	273,507,789	273,507,789	273,507,789
Номын Хишиг	1,780,000,000	1,780,000,000	1,780,000,000
ИЕТ	2,337,233,211	2,337,233,211	2,337,233,211
CryptoNation сан	950,000,000	950,000,000	950,000,000
<b>Бусад</b>	<b>5,372,994,959</b>	<b>5,236,573,869</b>	<b>6,574,397,878</b>
Богино хугацааны ХО	1,310,269,897	1,269,241,975	1,268,063,338
Эргэлтийн бус хөрөнгө	873,219,663	838,854,611	785,775,144
Бэлэн мөнгө	689,066,355	1,909,684	2,857,907
Цэвэр авлага	2,500,439,044	3,126,567,599	4,517,701,489
<b>Нийт үнэлгээ</b>	<b>44,424,823,637</b>	<b>46,330,306,467</b>	<b>47,502,890,195</b>
Эргэлтэнд буй хувьцаа	15,033,874	15,117,474	17,194,364
<b>Нэгж хувьцааны үнэлгээ</b>	<b>2,955</b>	<b>3,065</b>	<b>2,763</b>



## Санхүүгийн байдлын тайлан

Үлдэгдэл тэнцэл (сая төгрөгөөр)	2017Q4 A	2018Q1 B	2018Q2 C	C-A	C-B
Мөнгөн хөрөнгө	689,066	1,844	2,858	-100%	55%
Богино хугацаат хөрөнгө оруулалт	86,909	49,242	48,063	-45%	-2%
Авлага	4,799,347	4,752,479	625,133	-87%	-87%
Олгосон зээл	2,505,964	2,423,593	7,224,542	188%	198%
Бараа материал	23,176	24,671	19,933	-14%	-19%
Урьдчилж төлсөн тооцоо	423,914	379,682	1,020,259	141%	169%
Борлуулах зорилготой хөрөнгө	1,220,000	1,220,000	1,220,000	0%	0%
Үндсэн хөрөнгө	859,821	824,977	767,255	-11%	-7%
Биет бус хөрөнгө	14,217	13,877	18,520	30%	33%
Хөрөнгө оруулалт	39,033,913	41,093,727	40,928,492	5%	0%
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>49,656,326</b>	<b>50,784,093</b>	<b>51,875,056</b>	<b>4%</b>	<b>2%</b>
Дансны өглөг	1,265,008	502,798	169,637	-87%	-66%
Татвар, НДШ өглөг	67,354	8,775	82,466	22%	840%
Хүүний өр	57,744	51,771	70,412	22%	36%
Богино хугацаат зээл	1,080,073	1,121,276	1,311,836	21%	17%
Хойшлогдсон татварын өр	1,292,211	1,510,153	1,491,361	15%	-1%
Бондын өр төлбөр	2,781,782	2,769,192	2,779,433	0%	0%
<b>Нийт өр төлбөр</b>	<b>6,544,172</b>	<b>5,963,966</b>	<b>5,905,146</b>	<b>-10%</b>	<b>-1%</b>
Энгийн хувьцаа	1,879,653	1,879,653	1,879,653	0%	0%
Халаасны хувьцаа	-160,216	-160,216	-160,216	0%	0%
Нэмж төлөгдсөн капитал	9,929,061	9,929,061	9,929,061	0%	0%
Бодит үнэ цэнийн нөөц	7,364,020	9,436,217	9,270,394	26%	-2%
Хуримтлагдсан ашиг	24,099,637	23,735,412	25,051,019	4%	6%
<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>43,112,154</b>	<b>44,820,126</b>	<b>45,969,910</b>	<b>7%</b>	<b>3%</b>
<b>Нийт эх үүсвэрийн дүн</b>	<b>49,656,326</b>	<b>50,784,093</b>	<b>51,875,056</b>	<b>4%</b>	<b>2%</b>

## Орлого үр дүнгийн тайлан

мянган төгрөг	2017Q4 А	2018Q1 В	2018Q2 С	С-А	С-В
Хөрөнгө оруулалтын орлого	2,601,160	52,469	1,131,792	-56%	2,057%
Түрээсийн орлого	230,344	146,891	291,282	26%	98%
Менежментийн орлого	88,000	89,455	211,817	141%	137%
Хүүгийн орлого	529,602	78,189	170,550	-68%	118%
Ногдол ашгийн орлого	356,851	-	897,654	152%	100%
Бусад орлого	145,217	31,227	39,734	-73%	27%
<b>Нийт орлого</b>	<b>3,951,174</b>	<b>398,231</b>	<b>2,742,830</b>	<b>-31%</b>	<b>589%</b>
Борлуулалт маркетингийн зардал	201,182	36,451	147,736	-27%	305%
Боловсон хүчний зардал	918,407	148,778	307,055	-67%	106%
Үйл ажиллагааны зардал	1,208,511	393,533	866,261	-28%	120%
Санхүүгийн зардал	394,026	158,555	315,966	-20%	99%
Бусад зардал-хандив торгууль	10,339	8,752	19,829	92%	127%
<b>Зардлын дүн</b>	<b>2,732,466</b>	<b>746,069</b>	<b>1,656,846</b>	<b>-39%</b>	<b>122%</b>
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-76,259	-8,568	11,886	-116%	-239%
Биет хөрөнгө борлуулсны олз (гарз)	-11,367	-	-	-100%	
Олз гарзын дүн	-87,626	-8,568	11,886	-114%	-239%
<b>Татварын өмнөх ашиг</b>	<b>1,131,082</b>	<b>-356,406</b>	<b>1,097,869</b>	<b>-3%</b>	<b>-408%</b>
Орлогын татварын зардал	107,278	7,819	146,487	37%	1,773%
<b>Татварын дараах ашиг</b>	<b>1,023,805</b>	<b>-364,225</b>	<b>951,382</b>	<b>-7%</b>	<b>-361%</b>
Хөрөнгө оруулалтын үнэлгээний олз	4,642,382	2,072,197	1,906,374	-59%	-8%
<b>Нийт дэлгэрэнгүй ашиг</b>	<b>5,666,187</b>	<b>1,707,972</b>	<b>2,857,756</b>	<b>-50%</b>	<b>67%</b>

## Улирлын борлуулалт

Улирал	Тоо ширхэг	Өртөг	Нийт	Өөрчлөлт (улирлаар)	Өөрчлөлт (жилээр)
Q1 2017	60,940	2,148	130,926,300.00		
Q2 2017	68,622	2,289	157,095,740.00	0.1261	
Q3 2017	62,996	2,042	128,637,100.00	-0.082	
Q4 2017	428,013	2,418	1,034,763,200.00	5.7943	
Q1 2018	202,547	2,530	512,355,662.00	-0.5268	232.37%
Q2 2018	228,409	2,726	622,605,684.00	0.1277	232.85%

Анхаарал  
хандуулсанд  
баярлалаа!